Улсын ерөнхий прокурорын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А / 95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

√	Прокурорын байгууллагын бүтцийг шинэчлэн батлсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль 2017-12-07
Дагаж мөрдөх огноо:	2019-01-01
Албан тушаалын тодорхойлолтыг батлсан огноо:	2026-06-09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Улсын ерөнхий прокурорын газар	Тусгай хяналтын газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Тусгай хяналтын газрын дарга	Төрийн тусгай
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж 15/1
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэх, прокурорын байгууллагын хэмжээнд нууцын хадгалалт, хамгаалалтын ажлыг нэгтгэн зохион байгуулах.

Албан тушаалын зорилт:

1.Мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэх, прокурорын зөвшөөрөл олгох, үр дүнг хянаж баталгаажуулах;
2.Нэгж прокурорын газрууд болон эрх бүхий байгууллагуудын хэмжээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, биелэлт, үр дүнг тооцох;
3.Прокурорын байгууллагын хэмжээнд нууцын хадгалалт, хамгаалалтын ажлыг нэгтгэн зохион байгуулах;
4.Газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах- Т, Хариуцан гүйцэтгэх- Г Хянах- Х Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, “Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам”-д заасан нууц ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөл олгохоос татгалзах, тухайн ажиллагааны хугацааг сунгах, зогсоох арга хэмжээ авах.	Мөрдөн шалгах нууц ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан байна.	Х, Ш
	1.2.Улсын ерөнхий прокурорын баталсан “Гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналтын ажлын тухай заавар”, “Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам” болон холбогдох заавар, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих.	Журмын хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Г, Х
	1.3.Мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг хянах, холбогдох материалтай танилцах, нууц ажиллагааны магадлагааг хянаж баталгаажуулах.	Нотлох баримтын шаардлага хангасан байна.	Х, Ш
	1.4.Эрх бүхий байгууллагад мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахаар даалгавар бичиж гүйцэтгүүлэх, үр дүнтэй танилцах.	Даалгаврын үр дүнг тооцсон байна.	Г, Х
	1.5.Гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсхүл эрх бүхий байгууллагын ажилтан хууль тогтоомж зөрчсөн талаарх гаргасан гомдлыг хянаж, холбогдох арга хэмжээ авах.	Гомдлыг хянаж, шийдвэрлэсэн байна.	Г, Х, Ш
	1.6.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон прокурорын хяналтын харьяаллыг тогтоох.	Харьяаллыг үндэслэлтэй тогтоосон байна.	Г, Х, Ш
	1.7.Нууц хэрэг бүртгэлтийн хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар бүлэгт зааснаар хяналт тавих.	Хэргийн нууцлал, аюулгүй байдал хангагдсан байна.	Г, Х
	1.8.Эрүүгийн хэргийн нэгдсэн бүртгэл болон гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааны бүртгэл хөтлөх, хяналт тавих.	Бүртгэлийг үнэн зөв бүртгэсэн байна.	Г, Х
	1.9.Гүйцэтгэх ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан эсэхийг хянах, холбогдох баримт сэлттэй танилцах.	Гүйцэтгэх ажиллагаанд тавих хяналт хэрэгжсэн байна.	Г, Х, Ш
	1.10.Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан гүйцэтгэх ажиллагаа явуулах	Гүйцэтгэх ажиллагааг	Г, Х, Ш

	зөвшөөрөл олгох, зөвшөөрөл олгохоос татгалзах, тухайн ажиллагааны хугацааг сунгах, зогсоох арга хэмжээ авах.	хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан байна.	
	1.11.Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн нэгдсэн тоо бүртгэлд хяналт тавьж, төлөвлөгөөний дагуу биечлэн шалгах ажиллагааг зохион байгуулах.	Биечлэн шалгах ажиллагаа зохион байгуулсан байна.	Г, Х, Ш
	1.12.Хууль тогтоомж, Улсын ерөнхий прокурорын тушаал, түүгээр баталсан заавар, журмаар хариуцуулсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт явуулах, холбогдох арга хэмжээ авах.	Шалгалт хийж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Г, Х, Ш
	2.2.Улсын ерөнхий прокуророос эрх олгосон мөрдөн шалгах нууц ажиллагаанд хяналт тавих прокурорын шийдвэр, үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг зохион байгуулах, холбогдох арга хэмжээ авах.	Шалгалт хийж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Г, Х, Ш
	2.3.Гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохтой холбоотойгоор нэгж прокурорын газрын хяналтад байгаа хэрэг, материалтай танилцах, тайлбар танилцуулга авах.	Хяналтад байгаа хэрэг, материалтай танилцаж, тайлбар танилцуулга авсан байна.	Г, Х
	2.4.Мөрдөн шалгах нууц ажиллагаа болон гүйцэтгэх ажлын явц, үр дүнд дүн шинжилгээ хийж, Улсын ерөнхий прокурорыг мэдээллээр хангах, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	Улсын ерөнхий прокурорыг мэдээллээр хангасан байна.	Г, Х
	2.5.Хяналтын ажлын мэдээ, тайланд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт үр дүнг тооцох.	Мэдээ, тайланд үнэлэлт дүгнэлт өгч, тодорхой ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Нэгж прокурорын газруудын нууцын хадгалалт, хамгаалалтын байдал хууль, заавар, журамд нийцэж буй эсэхийг шалгаж, холбогдох арга хэмжээ авах, биелэлт үр дүнг тооцох.	Заавар, журмын хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	3.2.Прокурор, ажилтнуудад нууцад хамаарах хэрэг, материал, баримт бичгийг ашиглах, хамгаалах чиглэлээр мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх.	Мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн байна.	Г, Х

	3.3.Прокурорын байгууллагын хэмжээнд нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг нэгтгэн Тагнуулын байгууллагад хүргүүлэх.	Мэдээлэл хүргэгдсэн байна.	Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүхтэй харилцах чиглэлээр гаргах санал, хүсэлт, дүгнэлт, тайлбарын төслийг боловсруулах.	Үндэслэл бүхий мэдээлэл, санал, дүгнэлт, тайлбар боловсруулсан байна.	Г, Х
	4.2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журам, зааврын төсөлтэй танилцаж санал өгөх, мөн ирүүлсэн мэдээлэл, албан бичигт тайлбар хийх, зохион байгуулалтын шаардлагатай бусад арга хэмжээг авах.	Үндэслэл бүхий санал, тайлбар боловсруулсан байна.	Г, Х
	4.3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийн санал боловсруулж, биелэлтийг хангуулах.	Төлөвлөлтийг оновчтой хийж, биелэлтийг хангуулсан байна.	Х
	4.4.Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг танилцуулж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангуулах.	Санал гаргаж, шийдвэрлүүлсэн байна.	Г, Х
	4.5.Газрын прокурор, ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих.	Ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцсон байна.	Г
	4.6.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоос өгсөн үүргийг хэрэгжүүлж, хариуцсан чиг үүрэгтэй холбоотой мэдээллээр хангах.	Үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж, мэдээллээр хангасан байна.	Г
	4.7.Газрын хэмжээнд хяналтын ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүртгэл, судалгааг хөтлүүлж, хяналт тавих.	Бүртгэл хөтлөлтөд хяналт тавьсан байна.	Х
	4.8.Газрын чиг үүрэгт хамаарах асуудлаар зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, бодлого, зорилтыг уялдуулах.	Ажлын уялдаа холбоог хангасан байна.	Г, Х, Ш
	4.9.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, заавар, журам, стандартын хэрэгжилтийг хангах.	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	Эрх зүй (0421)

Мэргэшил	-хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй байх -хуульчийн багц цагийн сургалтад хамрагдсан байх	
Туршлага	Дээд шатны прокуророор 3-аас доошгүй жил, эсхүл Улсын ерөнхий прокурорын газарт ахлах прокуророор ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-газрын үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -прокурор, ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; -эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх.
	Дүн шинжилгээ хийх	-мэдээллийг цуглуулж, шалган нягтлах; -шийдвэрийн үр дагавар, эрсдлийг үнэлэх; -судалгааны арга зүйг ашиглан санал, дүгнэлт боловсруулах.
	Асуудал шийдвэрлэх	-хариуцсан ажлын явцад үүссэн асуудал, хүндрэл бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бодит мэдээлэлд үндэслэн тогтоох; -шийдвэрийн үр дагавар эрсдлийг урьдчилан тооцоолох; -хууль тогтоомжид нийцсэн оновчтой шийдвэр гаргах; -гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх.
	Манлайлах	-прокурор, ажилтнуудыг үлгэрлэн манлайлах; -ажлын байрны зэрэг орчныг бүрдүүлэх; -шинэ санаачилга болон өөрчлөлтийг дэмжих.
	Багаар ажиллах	-хамтын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох; -хариуцсан ажлыг багийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх; -мэдээллийг нээлттэй хуваалцах; -бусдын санал бодлыг хүндэтгэх.
	Бусад	-баримт бичиг боловсруулах; -хууль хэрэглэх; -ажлын ачааллыг оновчтой төлөвлөж, эрэмбэлэн зохион байгуулах; -албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийн систем, программ хангамжийг ашиглах, мэдээллийг цахим орчинд боловсруулах.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Улсын ерөнхий прокурор

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
1. Газрын ахлах прокурор 2. Газрын туслах ажилтан 3. Аймаг, нийслэл, тэсвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, түүний орлогч 4. Нийслэлийн прокурорын газрын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан прокурор Нийт: 4	1.Нэгж прокурорын газрын прокурор, ажилтан 2.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага 3.Шүүх 4.Бусад төрийн байгууллага 5.Иргэн, хуулийн этгээд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр	Байгууллагын нэр: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар: 2

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар: А/95

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН

2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр